

ХҮНИЙ НЭРИЙН СУДАЛГААНЫ ЗАРИМ АСУУДАЛ

Ц. Сувд *

Хорьдугаар зууны монгол хүний нэрийн судалгаанд тоон үзүүлэлт оруулж урд өмнө төдийлөн анзаарагдаж байгаагүй хэд хэдэн онцлог байгааг илрүүлэв. Үүнд монгол хүний нэрийн сангийн багтаамж, түүний ханах хандлага, нэрийн давтамж нэрийн тоо хоёрын урвуу хамаарал (цөөн давтамжтай нэр маш олон, олон давтамжтай нэр цөөн), хүний нэрийн сангийн гол цөмийг цөөн хэрэглээт нэр бүрдүүлдэг онцлог, нэрийн санд өчүүхэн хувь эзлэх түгээмэл нэрээр хүн амын ихэнх нь нэрлүүлж байгаа зэрэг онцлогийг дурдаж болно.

Ийм онцлог зүй тогтол бусад улс үндэстний хүний нэрэнд ч байх түгээмэл шинж чанартай болов уу гэсэн таамаглал дэвшүүлж, харьцуулсан судалгаа хийх шаардлага байгааг дурдсан. Хүн амынхаа тоогоор харилцан адилгүй улс орнуудын хүний нэрийн судалгаанд харьцуулалт хийхийн тулд нэрийн харьцангуй давтамжийг тодорхойлох шаардлагатай бөгөөд үүний тулд хүний нэрийг өргөн хэрэглээт түгээмэл нэр, дундаж хэрэглээт нэр, цөөн хэрэглээт нэр гэж 3 ангилах саналыг тавьж байна. Үүнээс гадна хүний нэр эзнийхээ заяа төөрөгт нөлөөлөх боломжийг философийн агуулга, хэлбэрийн категорид тулгуурлан тайлбарлах санааг гаргалаа.

Түлхүүр үг : хүний нэр, нэрийн сан, нэрийн давтамж, харьцангуй давтамж, нэрийн ангилал, харьцуулсан судалгаа, ерөнхий зүй тогтол, нэр ба заяа төөрөг

“Хорьдугаар зууны монгол хүний нэр” нэг сэдэвт бүтээлд бид монгол хүний нэрийн судалгаанд зарим тоон үзүүлэлт оруулснаар урьд өмнө нь төдийлөн анзаарагдаж байгаагүй хэд хэдэн онцлог байгаан илрүүлсэн билээ. Эдгээр онцлог зөвхөн монгол хүний нэрэнд хамаатай юу эсвэл аливаа улс үндэстний хүний нэрэнд нийтлэг байдаг үзэгдэл үү гэдгийг судлах нь сонирхол татаж байгаа юм.

Чухам ямар онцлогууд байна вэ гэвэл нэгдэх нь, хүний нэрийн сангийн багтаамжийн асуудалд хамаарна. Бидний судалгаагаар өнгөрөгч XX зуунд монголчууд 80550 нэр хэрэглэж ирсэн байна. Харин монголын казахуудад 27 мянга орчим хүний нэр байна. Эдгээр тоо монгол, казах үндэстний нэрийн сангийн багтаамжийг заана. Эндээс, олон арав, зуу, хэдэн зуун сая хүн амтай улс үндэстний хувьд хүний нэрийн

* Солонгосын Гадаад судлалын их сургууль, Монгол хэлний тэнхим

сангийн багтаамж нь ямар байх вэ гэдэг асуудал тавьж болно. Хүн амын тоо өсөхөд, хэрэглэгдэх нэрийн тоо дагаж өсөх нь гарцаагүй. Гэтэл монгол, казах үндэстний нэрийн харьцуулалтаас харахад (124 мянган монголын казахууд 27 мянган нэр хэрэглэж байхад 2,1 сая монголчууд ердөө л 85 мянган нэр хэрэглэж байна) нэрийн сангийн багтаамж буюу

Хэрэглэж байгаа нэрийн тооны хувьд ханах хандлага (хүний тоо өсч байхад хэрэглэгдэх нэрийн тоо төдийлөн өсөхгүй байх) ажиглагдсан болно.

Компьютерийн техник хөгжсөн өнөө үед дэлхийн янз бүрийн улс орнууд хүний нэрийн сангаа тодорхойлох тооцоог хийж, үнэхээр ийм ханалт байгаа эсэхийг тогтооход онцын төвөггүй юм. “Nice Investors Service Co.”-д байгаа БНСУ-ын 42 сая солонгос иргэний хувийн мэдээллээс авсан судалгаанаас үзвэл солонгосчууд 1 сая 394 мянган нэр хэрэглэж байна[6]. Судалгаанд хамрагдсан солонгос хүний тоо, монгол хүнийхээс 20 дахин их байгаа бөгөөд нэрийн сан дахь нэрийн тооны харьцаа нь 16,4 байна. Эндээс улс орны хүн амын тоо 2 саяд хүрсэн байхад нэрийн ханалт хангалттай явагдсан байдаг нь харагдаж байна. Энэ жишгээр авч үзвэл 140 сая хүнтэй орос оронд 8 саяас илүүгүй нэр байх ёстой юм.

Хоёрдахь онцлог нь нэрийн сангийн дотоод бүтцийн тоон үзүүлэлт, тухайлбал, нэрийн давтамжтай холботой юм. Бидний судалгаагаар нэрийн давтамж өсөхөд нэрийн тоо ерөнхийдөө огцом буурдаг зүй тогтол ажиглагдав. Үүнийг өмнө дурдсан 80550 нэрээс харж болно /Хүснэгт №1/.

Хүснэгтээс үзвэл, нэрийн сангийн үнэмлэхүй дийлэнх (97.14%)-ийг давтамж багатай цөөтэй цөөн хэрэглээт нэр эзэлж байна. Өөрөөр хэлбэл хүний нэрийн сангийн гол цөмийг цөөн хэрэглээт нэр бүрдүүлнэ гэсэн дүгнэлт хийж болохоор байна. Цөөн хэрэглээт нэрийн дотроос 1 давтамжтай буюу монголд ердөө ганцхан хүнд өгсөн нэр 49100 буюу нэрийн сангийн 61%-ийг эзэлж байна.

Тоон үзүүлэлтийн ийм онцлог бусад улс орнуудын хүний нэрэнд байгаа эсэхийг судлах нь сонирхолтой бөгөөд хүний нэрийн ерөнхий зүй тогтлыг илрүүлэхэд ач холбогдолтой юм. Тухайлбал өмнө дурдсан 42 сая солонгос хүний нэрийн дотор нэг давтамжтай нэр 547 мянга байгаа нь судалгаанд хамрагдсан солонгос нэрийн /1сая 394 мянга/ 40 орчим хувийг эзэлж байгаа нь харагдаж байна. Монголд ийм нэр 61 %-ийг эзэлж байгаагаас үзвэл нэг их зөрөөтэй биш байгаа нь харагдана.

Монгол хүний нэрийн санд цөөн хэрэглээт нэр 97,14%, дундаж хэрэглээт нэр 2.3%, өргөн хэрэглээт (түгээмэл) нэр үлдсэн 0.56%-ийг тус тус эзэлж байгааг энэ дашрамд дурдая. [3:18]

Гуравдахь онцлог нь, улс орнуудын хүний нэрийн харьцуулсан судалгаа хийхийн тулд нэгдсэн арга зүй байх ёстой. Ийм нэгэн арга зүйг бид өмнөх судалгаандаа дэвшүүлэн тавьсан билээ. Гол санаа нь хүний нэрийг: а/ цөөн хэрэглээт, б/ дундаж хэрэглээт, в/ өргөн хэрэглээт (түгээмэл) нэр гэж 3 ангилалд оршино. Энэ ангиллыг улс орны хүн амын тооноос хамааралгүй байхаар авч үзсэн. Энэ нь харьцангуй давтамж W гэсэн тоон үзүүлэлтийг оруулсанд оршиж байгаа юм.

Хүснэгт №1. Монгол хүний нэрийн сан дахь нэрсийг давтамжаар ангилах нь

№	Үнэмлэхүй давтамж, N	Харьцангуй давтамж, W	Нэрийн тоо
1	1	$4,8 * 10^{-7}$	49100
2	2-9	$9,6 * 10^{-7} < W < 4,3 * 10^{-6}$	22500
3	10-99	$4,8 * 10^{-6} < W < 4,7 * 10^{-5}$	6650
4	100-999	$4,8 * 10^{-5} < W < 4,8 * 10^{-4}$	1850
5	1000-1999	$4,8 * 10^{-4} < W < 9,6 * 10^{-4}$	193
6	2000-2999	$9,6 * 10^{-4} < W < 1,4 * 10^{-3}$	110
7	3000-3999	$1,4 * 10^{-4} < W < 1,9 * 10^{-3}$	48
8	4000-4999	$1,9 * 10^{-3} < W < 2,4 * 10^{-3}$	24
9	5000-5999	$2,4 * 10^{-3} < W < 2,9 * 10^{-3}$	29
10	6000-6999	$2,9 * 10^{-3} < W < 3,3 * 10^{-3}$	17
11	7000-7999	$3,3 * 10^{-3} < W < 3,8 * 10^{-3}$	9
12	8000-8999	$3,8 * 10^{-3} < W < 4,3 * 10^{-3}$	12
13	9000-9999	$4,3 * 10^{-3} < W < 4,8 * 10^{-3}$	5
14	10000 дээш	$W > 4,8 * 10^{-3}$	3
15	Бүгд		80550

Харьцангуй давтамж гэдэг нь тухайн нэрээр нэрлүүлсэн нийт хүний тоог улс үндэстний хүн амын тоонд харьцуулсан харьцаагаар тодорхойлогдоно. Бидний оруулж буй санал бол:

а/ $W > 0.001$ бол өргөн хэрэглээт /түгээмэл/ нэр,

б/ $0.0001 < W < 0.001$ бол дундаж хэрэглээт нэр,

в/ $0.0001 > W$ бол цөөн хэрэглээт нэр гэж

ангилахад оршино.

Харьцангуй давтамж а/ тохиолдолд буюу W нь 0.001-ээс их байвал тухайн нэр, мянган хүн тутамд нэг буюу түүнээс дээш тоотой давтагдаж байна гэсэн үг юм. Харин б/ тохиолдолд буюу W нь арван мянганы нэгээс их, мянганы нэгээс бага байвал тухайн нэр 10 мянган хүн тутамд 1-9 ийн хооронд давтагдана гэсэн үг бөгөөд в/ тохиолдол буюу W нь арван мянганы нэгээс бага байвал тухайн нэр 100 мянган хүн тутамд 1-9 хооронд давтагдаж байна гэсэн үг юм. Энэ үзүүлэлтээр аль ч улс орны хүний нэрийн судалгааг гаргаж болох бөгөөд үр дүнг нь харгалзуулан харьцуулах боломжтой. Харьцангуй давтамжаас гадна үнэмлэхүй давтамж (N)-ийг тодорхойлж болно. Үнэмлэхүй давтамж нь хүн амын нийт тоонд хуваахаас өмнөх үзүүлэлт болно. 1-р хүснэгт дээрх хоёр давтамжийг хоёуланг нь үзүүлсэн юм. Бидний судалгаанд хамрагдсан нийт монгол хүний тоо 2,1 сая учраас $N = 1$ гэсэн үнэмлэхүй давтамжид $W = N : 2,1 \text{ сая} = 4,8 * 10^{-7}$ гэсэн харьцангуй давтамж харгалзаж байгаа юм.

Дөрөвдэх онцлог нь, өмнө дурьдсан хүний нэрийн харьцангуй давтамжаас тухайн нэрээр нэрлүүлсэн хүний тоо руу шилжихэд урваж очдог явдал юм. Жишээлбэл, нэрийн санд нэг хүрэхгүй хувийг эзэлж байгаа түгээмэл нэрээр монголын хүн амын дийлэнх нь (1295376 хүн) нэрлүүлж байгаа бол нэрийн сангийн үнэмлэхүй дийлэнхийг (97.14%) эзэлдэг цөөн хэрэглээт нэрээр хүн амын дөнгөж 3.5% нь нэрлүүлж байна. [3:19] Ийм онцлог хүний нэрийн санд нийтлэг байх ёстой гэсэн таамаглал дэвшүүлж байна.

Тавдахь онцлог нь, аливаа улс үндэстний нэрийн сангийн насжилт (олон зуун жил тогтвортой хэрэглэгдэж ирсэн нэр болон шинэ, шинэхэн нэрс); харь хэлний гаралтай нэр, түүний утга холбогдол; оноосон нэрээс үүссэн нэр (газар ус, аймаг сум, хот, улс үндэстний нэрээс үүссэн нэр гэх мэт) ; нэрийн бэлгэдэл; нэрийн тольдол (нийгэм, түүх,

соёл, ахуйн болон сэтгэлзүйн тусгал); цээрлэсэн нэрийн зэрэг асуудлуудыг ч янз бүрийн улс орны хүний нэрэнд судалж харьцуулалт хийх нь улс үндэстнүүдийн соёл иргэншлийн нийтлэг болон ялгаатай талыг нээн илрүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

Судалгаанаас үзвэл, нүүдлийн соёл иргэншилтэй монголчууд эх болсон байгаль дэлхий, газар нутагтайгаа хүн холбоотой амьдарч ирсэн учраас оноосон нэрээс үүссэн монгол хүний нэрийн дотор монгол орны уул нуруу, нуур, гол мөрний нэрс олон байна.

Монгол хүний нэрийн санд буй төвд нэрс шашинтай хамт орж ирсэн учраас олонх нь бурхан шашны холбогдолтой нэр байдаг. Санскрит нэр буддын шашинтай шууд холбоотойгоор төвд, уйгараар дамжин монголд нэвтэрсэн учраас монгол хүний санскрит нэрийн багагүй хэсэг нь мөн л шашин мөргөлийн холбогдолтой утга бүхий үгээс бүтсэн байдаг ажээ. [2:113]

Орос болон европын бусад хэлнээс орж ирсэн нэр монгол хүний нэрийн санд өчүүхэн бага хувийг эзэлдэг бөгөөд орос болон европын бусад үндэстний түгээмэл хэрэглэдэг хүний нэрээр шууд нэрлэсэн нэр олонх нь байна. Харин орос гаралтай нэрсийн дотор Орос зөвлөлтийн цэргийн жанжин, нам, улс төрийн зүтгэлтнүүдийн нэрээс үүссэн нэр олон байдгаас гадна манай улсад шинээр нэвтэрч бий болсон эд юмс, ойлголт, техник технологи, цэрэг дайны холбогдолтой нэр ч цөөнгүй байдаг.

Монгол хүний нэрийн санд манж, хятад гаралтай нэрс маш цөөн тааралдаж байна. Хятад гаралтай нэр монгол хүний нэрэнд маш ховор байгаагийн гол шалтгаан нь Манж Чин улсын үед монгол хүнд хятад нэр өгөхийг хориглосон хууль гарган мөрдөж байсантай холбоотой болов уу. [1:49]

Хүний нэрийн судалгааны дараагийн асуудал нь нэрийн хөдлөц (динамик) –өд хамаарна. Бидний судалгаанаас үзвэл нэрийн хөдлөц, харьцангуй богино хугацаанд явагддаг гэсэн дүгнэлт гарч байгаа юм. Жишээлбэл, монгол хүн хүүхдэдээ орос нэр өгөх явдал 1940-50-иад оны үеэс эхэлж 1960-70 оны үед хамгийн их өгч, 1990-ээд оноос хойш орос нэр өгөхөө бараг больсон байна.

1921 оны ардын хувьсгал, социалист бүтээн байгуулалтын үеийн түүхэн хүмүүстэй холбоотой Сүхбаатар, Чойбалсан, Цэдэнбал, Цогтгэрэл гэх мэт нэрсийг 1960-70-аад оны үед олон хүүхдэд өгч байсан бол цаашдаа өгөх нь тасралтгүй багассаар ирсэн байна.

Монголд сүм хийдийг хааж, лам нарыг хилс хэргээр хороосон үеэс хойш төвд, санскрит нэр өгөх нь эрс багассан байна. Мөн сэхээтний төөрөгдөл хэмээн үндэстний үзлийн эсрэг явуулсан бодлогын улмаас Монголын их хаад, Чингисийн өрлөг жанжнууд, түүхэн эх орончдын нэр монгол хүний нэрийн сангаас хасагдаж байжээ. Харин 1990-ээд оноос Монгол улсад ардчилал, үндэсний ухамсар, шашин сэргэж эхэлсэн үеэс дээрх нэрсийг өгөх нь эргээд нэмэгдэх хандлагатай болж байна. Монгол хүний нэрзүйд гарч байгаа сүүлийн үеийн нэг өөрчлөлт бол харь гаралтай нэр өгөх нь багасч, эртний түүхт хүмүүсийн нэрийг өгдөг болжээ [4:364]

1940-өөд оноос Монголын нийгэм, улс төрийн хөгжлийн чиг хандлага үндсээрээ өөрчлөгдөж эхэлсэнтэй холбоотойгоор монгол хүний нэрийн сан 20-р зууны 40-өөд оноос эхлэн шинэ нэрсээр баяжих үйл явц эхэлсэн бөгөөд энэ нь 60-аад оны үед оргилдоо хүрч 80-аад он гэхэд эргээд хуучрах хандлагатай болжээ. Харин 90-ээд оноос өмнө дурдсан үйл явцын улмаас нэрийн шинэчлэлийн 2 дахь өрнөл эхэлсэн гэж үзэж байна.

Сүүлийн жилүүдэд эцэг эхчүүд хүүхдэдээ XX зууны түгээмэл нэрээс өгөх нь багасч нэг үгээс бүтсэн, ховор содон нэр өгөх хандлагатай болсон байна [3:68]. Хүний нэрийн тухайд улс орнуудын хувьд нийтлэг байж болох асуудлуудыг авч үзэхэд ийм байна.

Эцэст нь, хүний нэртэй холбоотойгоор хувь хүмүүс, олон нийтийн зүгээс сонирхож байдаг нэг асуудал бол тухайн нэр эзнийхээ амьдрал, аж төрөлд нөлөөтэй эсэх тухай асуудал юм. Төрсөн хүүхдэдээ ямар нэр өгөх нь эцэг, эх хувь хүний хэрэг мэт санагдавч тэрхүү нэр нь нийгмийн харилцаанд өдөр тутам орж бусдын хараа анхааралд ямагт өртөж, тодорхой үнэлэмж, сэтгэгдэл төрүүлж байдаг нь маргаангүй билээ. Өнөө цагт шинээр үүсч буй аж ахуйн нэгж, компаниуд нэрэндээ их анхаарал тавьдаг болсон байна. Ялангуяа гадныхантай харьцахад уг компаний нэр, нөгөө хэлэнд аль болох сонсголонтой, эерэг сэтгэгдэл төрүүлэхээр байх нь харьцаа холбоогоо бэхжүүлэхэд нь тус дөхөмтэй байдаг аж. Суудлын автомашинд өгсөн аятайхан нэр түүний борлуулалтад тодорхой хэмжээгээр эерэг нөлөөлдгийг зах зээл, маркетингийн судалгаагаар тогтоожээ. Ардчилсан холбооны удирдагчдын нэг, малыш хэмээх Б.Энхтүвшин “Америкт 10 жил ” номондоо: ... ажилд авсан менежер намайг Энки гэж дуудаж, түүнээс хойш бүтэн 10 жил миний Америк нэр Энки болсон доо. Энки гэдэг нэрийг америкчууд маш амархан тогтоодог. Энки Бэнки гэдэг ардын шахуу дуу байдаг. Энэ нэр эмэгтэйчүүдэд ихэд таалагддаг болохыг амархан анзаарсан. Япончууд мөн амархан тогтоодог. Учир нь Японд Бэнки гэдэг алдарт самурай, домогт баатар байдаг байна. Энхи нэрийг хятад гаралтай америкчууд мөн амархан тогтоодог. Учир нь энкай гэдэг нь пунтунхуа аялгуугаар Буяндэлгэрүүлэгч гэж ойлгогдож буудаг. Энхи гэдэг нь монголоор бол зүгээр Энхээ л байхгүй юу! Тиймд нэр их солигдсон юм байхгүй хирнээ Энки гэдэг нэр надад маш их аз завшааныг авчирсан ” хэмээн бичсэн байна [5].

Гүн ухааны үүднээс авч үзвэл нэр нь хэлбэр, нэрлүүлэгч нь агуулга нь юм. Иймд энэ асуудалд агуулга, хэлбэрийн харьцааны талаас хандах нь зүйтэй. Гүн ухаанд хэлбэр бол агуулгаасаа хамаардаггүй, огтоос идэвхгүй зүйл гэж үздэггүй. Хэлбэр нь идэвхтэй бөгөөд зарим тохиолдолд агуулгаа тодорхойлдог, агуулгынхаа шинэ шинэ талуудыг нээж гаргаж байдаг. Тэгвэл хүний нэр бол зүгээр нэг үг төдий биш эзнийхээ төөрөг заяанд нөлөөлж болохуйц зүйл гэж үзэх нь зүйтэй юм.

Сүүлийн үед барууны ертөнцөд “Таталцлын хууль” сэдвээр ихээхэн ярьж бичих боллоо. Энэ шуугиан дуулианы гол санаа нь хүний бодол санаа энергитэй, сайн болоод мууг даллан дуудах чадвартай гэж үзэхэд оршиж байгаа юм. Үүнийг аль хэдийн таньж мэдсэн монголчууд “Амны бэлгээс ашдын бэлгэ ” хэмээн үзэж тухайлбал үр хүүхдийнхээ цаашдын амьдралыг аз жаргалтай, амар амгалан, эрүүл энх байж урт насалж, элбэг баян амьдрахыг ерөөн бэлгэшээсэн утгатай үгсийг монгол хэлний арвин баялаг үгийн сангаас сонгон нэр өгсөөр иржээ. Түүнчлэн өшүүд нэр ч энэ л асуудалтай холбоотой бөгөөд нэрээр нь дамжуулж өвчин зовлон, гай тогтор, муу муухай юмнаас нуун хамгаалах гэсэн санаагаар ийм нэрийг өгдөг билээ.

НОМ ЗҮЙ

1. Монгол улсын түүх, V боть, УБ, 2003.
2. Ж. Сэржээ “Орчин цагийн монгол хэлний оноосон нэрийн судалгаа” УБ, 2011 он
3. Ц. Сувд “Хорьдугаар зууны монгол хүний нэр”, УБ, 2010 он
4. “Орчин цагийн монгол хэл” Ред. Ц. Өнөрбаян, А.Цог-Очир, Ү. Ариунболд, УБ, 2011он
5. Б. Энхтүвшин “Америкт 10 жил”,УБ, 2010 он
6. БНСУ-ын “Жүнг Анг” сонины 2012. 09.18-ны өдрийн дугаар

ABSTRACT

We have inserted quantitative indices into the research of XX century's Mongolian personal names and revealed several peculiarities which were not paid attention before. These include of fund capacity of Mongolian personal names, it's tendency to satisfy (when number of population is increased, in contrary, number of name in the name fund is not increased), inverse relationship between frequency and number of personal names (low-frequency names are much and high-frequency names are few), peculiarities that main part of personal names' fund is consist of few-spread names and majority of Mongolian population are given with the wide-spread names which are measly shared in the fund of personal names.

Therefore we have stated a hypothesis that above mentioned peculiarities and regularity are also may exist in the other nationalities' personal names and it needs comparative research. In order to make a comparison on the research for personal names of different countries which are different from each other on the number of its population, it requires determining relative frequency of personal names. So we put forward an idea that personal names are divided into 3 parts: wide-spread names, middle-spread names and few-spread names. Furthermore, in the basis on category of content and form, we tried to explain a possibility that personal names may influence destinies of their owners.

Key-words: personal names, fund of personal names, name frequency, relative frequency, name classification, comparative research, common regularity, name and destiny.